



ОРХОН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/17

Орхон аймаг

Дотоод хяналт, шалгалтыг зохион
байгуулах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын “Төрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1 Тус газрын “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг 2019 оны 4 дүгээр сар 17-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.


3. Батлагдсан журмын дагуу тухайн жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Баасансүрэн/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 15-ний өдөр батлагдсан журмыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ж.БАТ-ӨЛЗИЙ



Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн
А/19 дугаар тушаалын хавсралт



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн газрын /цаашид газар гэх/ хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Албан хаагчид нь Газрын даргын 2019 оны 04 дүгээр сар 17-ний өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан энэхүү "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" –ыг /цаашид журам гэх/ дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү журмыг "Төрийн хяналт шалгалтын тухай" Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг удирдлага болгоно.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

- 2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөлөөс ангид байх зарчимд тулгуурлана. Дотоод хяналт шалгалтыг явуулахдаа байгууллага, албан хаагчдын хэвийн үйл ажиллагаанд саад учируулахгүйгээр шуурхай явуулах зарчмыг баримтлана.
- 2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд байгууллагын хэмжээнд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.
- 2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх бөгөөд байгууллагын үндсэн үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.
- 2.4. Дотоод хяналт шалгалтын гаргасан аливаа шийдвэр хууль, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, заавал мөрдөх стандарт, байгууллагын дотоод журамд үндэслэсэн байна.
- 2.5. Дотоод хяналт шалгалтыг ямарваа нэгэн нэр хаяггүй мэдээлэлээр явуулахыг хориглоно.
- 2.6. Дотоод хяналт шалгалт нь дараах хэлбэрүүдтэй байж болно.
Үүнд:
 - Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус. Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан, тодорхой хугацаанд хийгдэж байгаа төлөвлөгөөт, цаг үеийн нөхцөл шаардлагаар төлөвлөгөөнд тусгагдаагүй нөхцөл байдлыг харгалзан хийх хяналт шалгалтыг төлөвлөгөөт бус хэлбэрээр гүйцэтгэнэ.
 - Хэсэгчилсэн хяналт шалгалтыг тухайн байгууллагын үйл ажиллагааны тодорхой чиглэл, нэгжийн үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлэх
 - Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар урьд хийсэн шалгалтын мөрөөр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэнд хийх
 - Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг санхүүгийн баримтын шалгалтаар гүйцэтгэх
- 2.7. Дотоод хяналт шалгалтын гаргасан аливаа шийдвэр байгууллагын болон нэгж, тасгийн удирдлага, шалгуулсан этгээд, хамт олон, хяналтын байгууллагад ил тод байна.
- 2.8. Дотоод хяналт шалгалтын гаргасан шийдвэр шударга, ижил зөрчилд адил арга хэмжээ авна.

**Гурав. Дотоод хяналт шалгалтыг
зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг**

- 3.1. Байгууллагын дотоод хяналт шалгалтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэнээр хийлгэх бөгөөд тухайн мэргэжилтнийг газрын даргын тушаалаар томилон ажиллуулна.
- 3.2. Дотоод хяналт шалгалтын албаны бүрэлдэхүүнд орж ажиллах ажилтан нь төр захиргаа, хууль эрх зүй, санхүү эдийн засгийн зохих мэдлэгтэй, байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх
- 3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь байгууллагын даргад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.
- 3.4. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь газрын явуулж байгаа үйл ажиллагаа, үйлчилгээний онцлогийг харгалзан тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг жилээр хийх бөгөөд хяналт шалгалт зохион байгуулахдаа тухай бүр удирдамж боловсруулж, байгууллагын дарга батлан гүйцэтгэнэ.
- 3.5. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан газрын албан хаагчдад мэдээлнэ.
- 3.6. Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтонд тусгахын зэрэгцээ тухайн албан хаагчийн үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхдээ харгалзан үзэж үнэлэх, үр дүнгийн урамшуулал олгож болно.
- 3.7. Хяналт шалгалтыг зохион байгуулахдаа шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийг байгуулах санал гарган шийдвэрлүүлэх бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эрх бүхий хууль, мэргэжлийн хяналтын байгууллага болон бусад байгууллагуудын /ТББ/ ажилтнуудын төлөөлөл оролцуулж болно.
- 3.8. Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна.
 - 3.8.1. Зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах
 - 3.8.2. Хяналт шалгалт явуулахдаа алба, тасгийн нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтан, албан хаагчийн ажлыг шалгаж танилцах, ажлын хэсэгтээ татан оролцуулах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах
 - 3.8.3. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
 - 3.8.4. Хяналт шалгалтаар зөрчил дутагдлуудыг тэмдэглэх мэдээллийн санг үүсгэн тэмдэглэл хөтөлж ажиллах, арилгасан зөрчлийн талаар нэгжийн удирдлага, албан тушаалтнаас ирүүлсэн дүгнэлийг хянаж, тайлбар ирүүлэхийг шаардах, хяналт тавин ажиллах
 - 3.8.5. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцуулах талаар байгууллагын удирдлагад санал тавих
 - 3.8.6. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах
 - 3.8.7. Холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах
 - 3.8.8. Дотоод хяналтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь

арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах

3.8.9. Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах

3.8.10. Шалгагдаж буй нэгж, ажилтны үндсэн үйл ажиллагаанд бодитой үнэлгээ хийх зорилгоор олон нийтээс санал асуулга авч дүгнэлтдээ тусгах

3.8.11. Ажлын арга хэлбэр, тэргүүн туршлага, оновчтой саналыг мөн дүгнэлтдээ тусган нийтэд мэдээлэх, ажилтан албан хаагчийг шагнаж урамшуулах талаар санал оруулах, байгууллагын удирдлагад танилцуулах

3.8.12. Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх

3.8.13. Энэхүү журмын 3.7-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан албан хаагчид дарамт шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

3.9. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээлэлийн сан бүрдүүлэх

3.10. Дотоод хяналт шалгалт, зөрчил түүний шийдвэрлэлтийг бүртгэх, дотоод хяналт, шалгалтын аливаа материалыг хадгалах үүрэгтэй.

3.11. Шинээр ажиллагсад байгууллагын болон дотоод хяналтын дүрэм журмаа танилцуулах үүрэгтэй.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

1.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулах бөгөөд зарим чиглэлийн шалгалтанд уг асуудлыг хариуцсан албан хаагч нарыг татан оролцуулах, мэргэжлийн арга зүйн туслалцаатайгаар дотоод хяналт шалгалтыг хийнэ.

Үүнд:

- Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрүүд, аймаг сумын Засаг даргын гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт
- Байгууллагын дотоод болон гадна орчны хог хаягдал, бохирдолт, ариун цэврийн хэрэгжилт
- Иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний ил тод, чирэгдэлгүй, ёс зүй, хариуцлага, манлайлах чадварт тавих хяналт шалгалт
- Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн харилцааны хүрээний хэрэгжилт
- Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт хадгалалт, санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаа
- Байгууллагын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг хэрхэн гүйцэтгэж байгааг нягтлах
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа авто тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, барилга байгууламжийн ашиглалт
- Архив, бичиг хэрэг хөтлөлтийн стандартыг ханган ажиллаж буй байдал

1.2. Дотоод хяналт шалгалтын хүрээнд гарч байгаа зөрчил дутагдлыг судлан дүгнэлт гаргаж, холбогдох сургалтын төлөвлөгөөг гарган ажиллах

1.3. Албан хаагч нарын дунд гарч болзошгүй зөрчил дутагдлыг илэрүүлэх зорилгоор улиралд 1-ээс доошгүй удаа социологийн судалгаа явуулж ажиллах бөгөөд судалгааны дүнг удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллана.

1.4. Дотоод хяналт шалгалтын үр дүнг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаас туслалцаа авч шалган туслах үйл ажиллагааг хийлгэж болох бөгөөд гарсан дүгнэлтийг тэмдэглэн хөтөлж, хэрэгжилтийг илтгэн танилцуулж ажиллах

Тав. Хариуцлага

- 5.1. Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.
- 5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад, хүний амь нас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц байвал орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж, шийдвэрлүүлнэ.